



МОНГОЛ АЛТ ХК

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2024 оны 03 сарын 18-ны өдөр

№ 02

Дархан-Уул аймаг

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах тухай

Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.10, 60 дугаар зүйлийн 60.1, 60.2, 60.4, 71 дүгээр зүйлийн 71.1, 71.3, “Монгол Алт” хувьцаат компанийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.2, 8.4.10, Санхүүгийн Зохицуулах Хорооны 2018 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 377 дугаар тогтоолоор баталсан “Хувьцаат компанийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”-ыг тус тус үндэслэн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаас ТОГТООХ НЬ:

1. “Монгол Алт” Хувьцаат Компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал (цаашид “хурал” гэх)-ыг 2024 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн 11:00 цагт Монгол Улс, Дархан-Уул аймаг 7 дугаар баг, Хуульчдын 3 гудамжны 301 тоот, Монгол Алт ХК-ийн байрны хурлын танхимд зарлан хуралдуулсугай.
2. Хурал зарлах тухай мэдэгдлийг 2024 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн дотор Санхүүгийн Зохицуулах Хороо, Монголын Хөрөнгийн Биржид тус тус хүргүүлсүгэй.
3. Хурал хуралдуулах тухай зар мэдээг Монголын Хөрөнгийн Биржийн цахим хуудас, өдөр тутмын хоёроос доошгүй сонин болон бусад хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан 2024 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн дотор нийтэд мэдээлж, уг зарын давталтыг 2024 оны 04 сарын 08-ны өдөр анх зарласан хэлбэрээр дахин нийтэд мэдээлсүгэй.
4. Хуралд оролцох эрхтэй Хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2024 оны 04 дүгээр сарын 07-ны өдрөөр тогтоосугай.
5. Хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалт, гарах шийдвэрийн төсөл, танилцуулга, саналын хуудас зэрэг бусад баримт бичгийг 2024 оны 03 дугаар сарын 25-ний өдрөөс өмнө үнэт цаасны брокер, дилерийн компаниудад хүргүүлэхийг Гүйцэтгэх захирал (М.Цолмон)-д үүрэг болгосугай.
6. Хурлын даргаар Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Л.Амарсанааг томилсугай.
7. Хурал зохион байгуулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай. Үүнд:
 - 7.1. Хурал зохион байгуулах комиссын дарга:
 - 7.1.1. Гүйцэтгэх захирал М.Цолмон.
 - 7.2. Хурал зохион байгуулах комиссын гишүүд:

7.2.1. Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга С.Бат-Эрдэнэ.

7.2.2. Хүний нөөцийн ажилтан Х.Одгэрэл.

8. Хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалтыг НЭГДҮГЭЭР хавсралтаар, саналын хуудасны загварыг ХОЁРДУГААР хавсралтаар, Хурлын нийтэд хүргэх зарыг ГУРАВДУГААР хавсралтаар, Хурлаар хэлэлцэх асуудалтай холбоотой материалын жагсаалтыг ДӨРӨВДҮГЭЭР хавсралтаар тус тус баталсугай.
9. Хувьцаа эзэмшигчдийн санал хүлээн авах эцсийн хугацааг 2024 оны 04 дүгээр сарын 29-ны өдрийн 10:00 цаг байхаар тогтоосугай.
10. Хувьцаа эзэмшигчдийг Хурлын материалтай танилцах нөхцөл боломжийг бүрдүүлж ажиллахыг Хурал зохион байгуулах комисс (М.Цолмон)-д даалгасугай.
11. Хурлын тооллогын комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай. Үүнд:
 - 11.1 Хурлын тооллогын комиссын дарга:
 - 11.1.1. Маркетингийн Г.Сарнай.
 - 11.2. Хурлын тооллогын комиссын гишүүн:
 - 11.2.1. Хүний нөөцийн ажилтан Х.Одгэрэл.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ДАРГА



Л.АМАРСАНАА